

# Монгол улс - НҮТС 2018

**Үндэсний статистикийн хороо - УИХ**

Үүссэн огноо: October 11, 2019

Вэб хуудас: <http://web.nso.mn/nadamn/index.php>

## Ерөнхий мэдээлэл

### Тодорхойлолт

ДУГААР  
DDI-MNG-NSO-MN-SISS-2018-v1.0

### Хувилбар

ХУВИЛБАРЫН ТАЙЛБАР  
Хувилбар 1.0

ҮҮССЭН ОГНОО  
2019-08-02

## Ерөнхий мэдээлэл

### ТОВЧ

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) Хүүхэд хөгжил судалгаа (НҮБ-ын Хүүхдийн сангаас боловсруулсан Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа-ОУБТС)-г 1996, 2000, 2005, 2010 онуудад ОУБТС-ны стандарт аргачлал, арга зүйг ашиглан 4 удаа, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааг 1998, 2003, 2008 онуудад Хүн ам зүй, эрүүл мэндийн Олон улсын судалгааны аргачлалыг баримтлан 3 удаа зохион байгуулсан. Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн “е”-д “нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг 5 жил тутам” зохион байгуулж явуулахаар хуульчилсан. Түүнчлэн, УИХ-аас баталсан Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газраас баталсан Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, Хүн амын хоол тэжээлийн үндэсний хөтөлбөр зэрэг үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд шаардлагатай тоо мэдээллийг цуглуулна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд:

1. хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.
2. хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлнэ.
3. хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлнэ.
4. нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаална.

тэгш боломж олгох нийгмийн хамгааллыг дэмжих замаар хүүхдийн орлогын болон орлогын бус ядуурлыг бууруулна.

МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ  
Sample survey data [ssd]

СУДАЛГААНЫ НЭГЖ  
Өрх болон өрхийн гишүүд

### Хүрээ

#### ТЭМДЭГЛЭЛҮҮД

- өрх: өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл, өрхийн гишүүдийн боловсрол, өрхийн зарим үзүүлэлт, ус хангамж болон

ариун цэврийн байгууламж, гар угаах газар, иоджуулсан давсны хэрэглээ

- эмэгтэй: ерөнхий мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээ, төрөлтийн түүх, жирэмслэлт, эх, нялхсын эрүүл мэнд, төрсний дараах хяналт, жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл (жсах)-ийн хэрэглээ, гэрлэлтийн байдал, насанд хүрэгчдийн үйлдлийн чадвар, бэлгийн замаар дамжих халдвар, хдхв/дох-ын талаарх мэдлэг, хандлага, умайн хүзүүний хорт хавдар, тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ

- эрэгтэй: ерөнхий мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээ, төрсөн хүүхдийн тоо, гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага, гэрлэлтийн байдал, насанд хүрэгчдийн үйлдлийн чадвар, бэлгийн харьцааны төлөвшил, бэлгийн замаар дамжих халдвар, хдхв/дох-ын талаарх мэдлэг, хандлага, тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ

- хүүхэд: ерөнхий мэдээлэл, хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн хүмүүжил, эцэг, эхийн оролцоо, сурах суурь чадвар, сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил, эхийн сүүгээр хооллолт ба хүүхдийн хоол тэжээл, вакцинжуулалт, хүүхдийн өвчлөл, эмчилгээ, сувилгаа

## Ажиглалтын хүрээ

### ГАЗАР ЗҮЙН ХҮРЭЭ

Судалгаанд 21 аймаг, Нийслэлийн 9 дүүрэг бүхэлдээ хамрагдана. Монгол Улсын “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018”-ын үр дүнг үндэсний түвшинд, үүний дотор хот, хөдөө, бүсээр (Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар) тооцоход хангалттай төлөөлөлтэй байхаар түүврийн хэмжээг тогтооно. Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн хөтөлбөр хэрэгжиж буй 6 аймаг (Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Өмнөговь), 2 дүүрэг (Баянзүрх, Налайх), НҮБ-ын Хүн амын сангийн хөтөлбөр хэрэгжиж буй 1 аймаг (Өмнөговь)-ийн хувьд төлөөллийг хангасан түүврийг хэмжээг тогтооно.

### ХҮРЭЭ

Энэхүү судалгаанд өрхийн бүх гишүүдийн ерөнхий мэдээлэл (байнга оршиг суугч), 15-49 насны бүх эмэгтэйчүүд, 15-49 насны бүх эрэгтэйчүүд, 0-5 нас болон 5-17 насны бүх хүүхдүүд хамрагдана.

## Гүйцэтгэгч болон түнш

### ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА

Нэр	Харьяалал
Үндэсний статистикийн хороо	УИХ

### САНХҮҮЖИЛТ

Нэр	Товчилсон үг	Үүрэг
НҮБ-ын Хүүхдийн сан	UNICEF	Санхүүжилт хийсэн.
НҮБ-ын Хүн амын сан	UNFPA	Санхүүжилт хийсэн.

## Мета мэдээллийн боловсруулалт

### БОЛОВСРУУЛСАН

Нэр	Товчилсон үг	Харьяалал	Үүрэг
Үндэсний статистикийн хороо	ҮСХ	УИХ	Баримтжуулалт хийсэн

МЕТА МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛСАН ОГНОО  
2019-09-12

БИЧИГ БАРИМТЫН ХУВИЛБАР  
v1.0

БИЧИГ БАРИМТЫН ДУГААР  
DDI-MNG-NSO-MN-SISS-2018-v1.0

## Түүвэрлэлт

### Түүвэрлэлт

---

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа өрхөд суурилсан судалгаа учраас түүврийн нэгж нь өрх юм. Хүүхэд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үзүүлэлтүүдийг үндэсний түвшинд, үүний дотор хот, хөдөө, бүсээр (Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар) болон зорилтот 6 аймаг (Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Өмнөговь), 2 дүүрэг (Баянзүрх, Налайх)-ээр тооцоход хангалттай төлөөлөлтэй байхаар түүврийн хэмжээг тогтоосон. Улсын хэмжээнд 14,500 өрхийг судалгаанд хамруулж, бүс бүрт ногдох өрхийн тоог квадрат язгуурын аргаар тооцсон.

Өрхүүдийг сонгохдоо 2 шатлалт, бүлэглэсэн түүврийн аргыг ашиглав. Эхний шатанд судалгаанд хамрагдах түүврийн анхан шатын нэгжийг (сегмент) хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар тодорхойлсон. Сонгогдсон ТАШН бүрийн хувьд өрхийн жагсаалтыг 2018 оны 8-9 сард шинэчлэн гаргуулсны дараа судалгаанд хамруулах өрхийн тоог 25 байхаар тооцож, өрхүүдийг системчилсэн магадлалт түүврийн аргаар сонголоо.

### Түүврийн жин

---

НҮТС-ны өрхийн бүрэн (ямар нэгэн засварлалт хийгээгүй) жин нь өрхийн сонгогдох магадлалын урвуу харьцаа болон страта бүрийн хамрагдаагүй хувийг засварласан коэффициентийн үржвэрээр тодорхойлогдсон. Түүврийн зохиомж нь судалгаанд хамрагдсан нэгжүүд улсын хэмжээний нийт өрхийг төлөөлөхүйц магадлалтайгаар хийгдсэн тул ярилцлага өгсөн өрхийн жинлэсэн нийлбэрийг нийт түүврийн хэмжээтэй тэнцүү байхаар тооцож стандартчилсан (нормальчилсан). Нормальчлахдаа түүврийн бүрэн жинг (хамрагдаагүй хувиар засварласан) улсын хэмжээний бүх өрхийн бүрэн жингийн дунджид харьцуулсан. Үүнийг гүйцэтгэхдээ түүврийн жинг улсын хэмжээнд өрхүүдийн жинлээгүй тоог нийт өрхийн жинлэсэн тоонд (түүврийн бүрэн жинг хамрагдаагүй хувиар засварласан) харьцуулсантай тэнцүү байх тогтмол коэффициентээр үржүүлсэн. Үүнтэй адилаар ганцаарчилсан асуулгад хамрагдсан хүн бүрт (эрэгтэй, эмэгтэй, 5 хүртэлх болон 5-17 насны хүүхэд, усны чанарын сорилд) нормальчилсан түүврийн жинг тооцсон. Түүврийн жингийн тооцооллоос үзэхэд нийт 580 ТАШН бүрийн өрхийн засварласан (нормальчилсан) жин 0.1710-аас 4.2085-ын хооронд хэлбэлзэж байв.

Зорилтот аймаг/дүүргийн хувьд өмнөхтэй адилаар тухайн аймаг/дүүргийн түвшний нормальчилсан жингүүдийг өрх, эрэгтэй, эмэгтэй, 5 хүртэлх болон 5-17 насны хүүхэд, усны чанарын сорил бүрээр мөн тооцсон.

Түүврийн жинг бүх өгөгдлийн файлд хавсаргасан ба дүн шинжилгээ хийхдээ өрх, эмэгтэй, эрэгтэй, 5 хүртэлх болон 5-17 насны хүүхэд, усны чанарын сорил мэдээллийг дээрх жингүүдээр жинлэсэн болно.

## Асуулгууд

No content available

## Мэдээлэл цуглуулалт

### Мэдээлэл цуглуулалтын огноо

Эхлэх	Дуусах	Цикл
2018-09-20	2018-12-20	Өдөр бүр

### Хугацааны үе

Эхлэх	Дуусах	Цикл
2018-09-20		Өдөр бүр

### Мэдээлэл цуглуулалтын бодлого

Computer Assisted Personal Interview [capi]

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

ТУРШИЛТЫН СУДАЛГАА - Асуулгын туршилтыг 2018 оны 5 сард Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, Хушаат сум, Улаанбаатар хотын Налайх дүүргийн нийт 5 нэгжид зохион байгуулсан. Туршилтын судалгааны үр дүнд суурилан асуулгын хуудсанд зохих засвар хийж, асуулт хоорондын уялдааг сайжруулсан.

СУРГАЛТ: Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтнуудад зориулсан сургалтыг 160 хүнийг хамруулж, 8 сарын 20-ноос 9 сарын 21-ний хооронд нийт 30 хоногийн хугацаанд зохион байгуулсан. Сургалтад ярилцлага авах арга зүй, асуулгын хуудас тус бүрийн агуулгыг зааснаас гадна цаасан асуулгаар, таблет ашиглан бие биенээс нь ярилцлага авахуулсан. Сургалтын эхний 20 хоногт цаасан асуулга, үлдсэн 10 хоногт нь таблетийн хичээл заав.

Сургалтын явцад цаасан асуулгын дадлагыг 2 өдөр Баянзүрх дүүргийн 2 дугаар хороонд, таблет асуулгын дадлагыг мөн 2 өдөр Баянзүрх дүүргийн 5 дугаар хороонд зохион байгуулж айлуудаар орж судалгаа авсан. Сургалтын хөтөлбөр, зохион байгуулалтыг ОУБТСБ-ын стандарт хөтөлбөрийг үндэслэн боловсруулж, зохион байгуулсан. Мөн онцгой байдлын нөхцөлд хэрхэн ажиллах, нохойтой хэрхэн харьцах, харилцааны болон багийн сэтгэлзүйн талаар нэмэлт хичээлийг хөтөлбөртөө тусган оруулсан.

Сургалтын явцад хүүхдийн өндөр, жин хэмжих, усны чанар шалгах хичээлийг 4 өдөр тусгайлан зааж, хүүхдийн өндөр, жин хэмжих дадлага 1 өдөр, усны чанар шалгах дадлага 1 өдөр хийсэн.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын багийн ахлагчаар ажиллах хүмүүстээ багийн ахлагчийн үүрэг, хариуцлага, хийх ажлын талаар, мэдээлэл цуглуулалтыг орон нутагт хэрхэн зохион байгуулах тухай нэмэлт сургалтыг зохион байгуулав.

Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт - Судалгааны мэдээлэл цуглуулалтад нийт 19 баг ажилласан, баг тус бүр багийн ахлагч, 5 ярилцлага авагч (2 эрэгтэй нь хүүхдийн өндөр, жин хэмжих, усны чанар шалгах тест хийх ажлыг хариуцан гүйцэтгэсэн), 2 жолооч гэсэн бүрэлдэхүүнтэй байв. Мэдээлэл цуглуулалтын ажил 2018 оны 9 сарын 21-нээс Улаанбаатар хотод, 10 сарын 3-наас орон нутагт эхэлж 12 сарын 28-ныг дуустал нийт 99 хоног үргэлжилсэн. Судалгаанд ашигласан технологи - Судалгааны мэдээлэл цуглуулалтад Windows 10 үйлдлийн систем бүхий таблет ашигласан бөгөөд Bluetooth програмын тусламжтай багийн гишүүд өөр хоорондоо шаардлагатай мэдээллийг дамжуулж байв.

### Мэдээлэл цуглуулалт

Нэр	Товчилсон үг	Харьяалал
Үндэсний статистикийн хороо	ҮСХ	УИХ

# Мэдээлэл боловсруулалт

## Мэдээлэл засалт

---

Мэдээлэл цуглуулалтын явцад ярилцлага авагч нарын цуглуулсан мэдээлэл багийн ахлагчийн таблет дээрх програмд нэгтгэгдэж, тухай бүр хянаж, шаардлагатай тодруулгыг хийсний дараа багийн ахлагч интернет ашиглан ҮСХ-ны төв серверт нэгтгэсэн мэдээллийг дамжуулж байв. Програмд шинэчлэл хийсэн тохиолдолд багийн ахлагч ҮСХ-ны төв серверт мэдээлэл дамжуулах үед багийн ахлагчийн программ шинэчлэгдэхээр зохион байгуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулалт дууссаны дараа мэдээллийн уялдааг шалган шаардлагатай засвар хийхдээ ОҮБТС6-ын стандарт удирдамжийг мөрдөж байлаа.

Судалгааны үр дүнгийн үзүүлэлтүүдийг тооцож, хүснэгтлэн боловсруулахдаа Нийгмийн шинжлэх ухаанд ашигладаг статистикийн багц програм SPSS 24.0-ийг ашигласан. Мөн судалгааны үр дүнг боловсруулахдаа ОҮБТС6-ын стандарт синтакс, хүснэгтийг ашиглахаас гадна өөрийн улс орны хэрэгцээ шаардлага, онцлогт суурилан шаардлагатай хүснэгт, үзүүлэлтүүдийг нэмж тооцсон болно.



## Мэдээллийн үнэлэлт

No content available

